

САЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ

БАТЛАВ.

О.АЮУШБААТАР

**САЙХАН СУМЫН ЗДТГ, УУЛ УУРХАЙН ААНБ-ИЙН  
ХООРОНД БАЙГУУЛСАН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

1320020009 СЭТ0028 9055185

2021 оны 07-р сарын 29-ны өдөр

Сайхан сум

**Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиудыг үндэслэн энэхүү гэрээг:

Нэг талаас Сэлэнгэ аймаг Сайхан сумын "Нутгийн захиргааны байгууллага" гэх /төлөөлж/ Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Ууганжаргал нөгөө талаас "Ноён-ширхэнцэг" ХХК-ийг төлөөлж *Т.У.З-ийн* *З.Э.О.* албан тушаалтай *Б.З.М.У.Л.А.*

нар нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3 б дахь заалт, 29.1.3 е дэх заалт, 29.1.3 н дэх заалтуудыг тус тус үндэслэн дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх тогтвортой бичил уурхайг хөгжүүлэхэд оршино.

**Хоёр. Уул уурхайн аж, ахуй нэгж байгууллагын хүлээх үүрэг**

- 2.1. Суманд өрнөж байгаа бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хөрөнгө оруулалт болон санхүүгийн бодит дэмжлэг үзүүлэх
- 2.2. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд орон нутагтай хамтарч ажиллах
- 2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн газарт амьдарч байгаа иргэдийн аюулгүй байдал хангах
- 2.4. Жилд сумын харъяат 5-аас доошгүй иргэдийг ажлын байраар хангаж ажиллах
- 2.5. Уул уурхайн ил тод байдлыг хангах
- 2.6. Сайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид сар бүр тухайн орд газрынхаа нөөц болон олборлолт явуулсан мэдээ тайланг ирүүлж байх
- 2.7. Эвдрэлд орсон газрын байгаль орчныг нөхөн сэргээх, мод, бут, сөөг, олон наст ургамал тарих

**Гурав. Засаг даргын тамгын газрын хүлээх үүрэг**

- 3.1. Сумын нутаг дэвсгэр дээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 3.2. Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д үндсэн үйлдвэрлэлээс гадна бусад ажил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.
- 3.3. Уурхайн ажиллагсадыг орон нутагтаа аялуулах, амраах чиглэлээр хамтран ажиллана.
- 3.4. Сумаас уурхайн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл солилцоно.

3.5. Тухайн ААНБ-ын ажилтан, албан хаагчдад хэрэгцээний мах, сүү, цагаан идээг сумын малчин айл өрхтэй тохиролцон хөнгөлттэй үнээр худалдан борлуулахад хамтарч ажиллана.

#### **Дөрөв. Хамтран хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд**

- 4.1. Сумын иргэдийг ажилтай орлоготой болгох
- 4.2. Суманд хэрэгжих томоохон төсөл /орон сууц, зам гүүр, дэд бүтэц гэх мэт/ хэрэгжүүлэхэд хамтран оролцох
- 4.3. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах
- 4.4. Сумын иргэд болон тухай ААНБ-ын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- 4.5. Уул уурхайн сургалт, дадлага хийхэд хамтран ажиллана.
- 4.6. Амьдралын боломж муутай айл өрхүүдэд дэмжлэг үзүүлэх

#### **Тав. Бусад болон Хариуцлага**

- 5.1. Хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй улсын байцаагчийн тавьсан шаардлагыг үл хүндэтгэсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцогдох мөн түүнчлэн ААНБ-ын тусгай зөвшөөрлийг холбогдох газарт уламжилж цуцлах хүртэл арга хэмжээ авах болно.
- 5.2. Энэхүү гэрээг 2021 оны 07 сарын 29-ний өдрөөс 2022 оны 06 сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаагаар байгуулав.
- 5.3. Дээрхи гэрээг жил бүр тогтмол дүгнэж байх бөгөөд гэрээний аль нэг тал үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн нь гэрээг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

БАЙГАЛЬ ОРЧНЫ

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

М. УУГАНЖАРГАЛ

НОЁН ШИРХЭНЦЭГ ХХК-ЫГ ТӨЛӨӨЛЖ

ЗАХИРАЛ

Б.ЗОЛЖАРГАЛ

